

МОНГОЛЬСКАЯ
АКАДЕМИЯ НАУК
Институт истории и
этнологии

МЕЖДУНАРОДНАЯ
АССОЦИАЦИЯ
МОНГОЛОВЕДОВ

РОССИЙСКАЯ
АКАДЕМИЯ НАУК
Институт восточных
рукописей



КУЛЬТУРНОЕ НАСЛЕДИЕ МОНГОЛОВ: КОЛЛЕКЦИИ РУКОПИСЕЙ И АРХИВНЫХ ДОКУМЕНТОВ

IV

**Международная конференция
при поддержке Президента Монголии**



18-19 апреля, 2019. Улан-Батор

Сборник докладов

Санкт-Петербург — Улан-Батор
2021

ННА 63.4
ДAA 930.1
М-694

Ответственный редактор:	Академик С.Чулуун
Научные редакторы:	доктор филол. наук И.В.Кульганек Ph.D Н.Хишигт
Редакторы, составители:	Ph.D Б.Нацагдорж канд. филол. наук. Н.С.Яхонтова

Культурное наследие монголов: коллекции рукописей и архивных документов. Сборник докладов IV международной научной конференции. 18—19 апреля 2019 г. Улан-Батор. Россия. СПб.—УБ. 2021 г. —276 с.,

Сборник представляет собой собрание докладов IV международной научной конференции “Культурное наследие монголов: коллекции рукописей и архивных документов”, организованной Институтом истории и археологии МАН, Ассоциацией международных монголоведов и Институтом восточных рукописей РАН в г. Улан-Батор, 18—19 апреля 2019 г.

Основой для конференции стали рукописные фонды и архивы, хранящие документы и материалы по истории, культуре, этнографии, политике, языку монгольских народов. В сборнике публикуются доклады, освещающие историю монголоведения, а также доклады, посвященные рукописным материалам о материальной культуре монголов, их письменному наследию, художественному творчеству, экспедициям и разным сторонам жизни традиционного и современного монгольского общества.

ISBN 978-9919-9646-7-2
DOI 10.25882/z7ch-tr43

© Институт истории и этнологии МАН, 2021 г.
© Институт восточных рукописей РАН, 2021 г.
© Международная ассоциация монголоведов, 2021 г.

МОНГОЛ УЛСЫН
ШИНЖЛЭХ УХААНЫ
АКАДЕМИ
Түүх, угсаатны зүйн
хүрээлэн



ОЛОН УЛСЫН
МОНГОЛ СУДЛАЛЫН
ХОЛБОО



ОРОСЫН ШИНЖЛЭХ
УХААНЫ АКАДЕМИ
Дорно дахины гар
бичмэлийн хүрээлэн



МОНГОЛЧУУДЫН СОЁЛЫН ӨВ: ГАР БИЧМЭЛ БА АРХИВЫН БАРИМТЫН ЦУГЛУУЛГА

IV

Монгол улсын ерөнхийлөгчийн ивээл дор
зохион байгуулсан



Олон улсын эрдэм шинжилгээний хурал

2019 оны 4 сарын 18-19
Монгол улсын Улаанбаатар хот

Илтгэлүүдийн эмхэтгэл

Санкт-Петербург - Улаанбаатар
2021

ННА 63.4
ДАА 930.1
М-694

Хариуцлагатай редактор: Академич С.Чулуун

Эрдэм шинжилгээний редактор:

Хэл бичгийн ухааны доктор И.В.Кульганек

Түүхийн ухааны доктор (Ph.D) Н.Хишигт

Редактор, эмхэтгэгчид:

Түүхийн ухааны доктор (Ph.D) Б.Нацагдорж

Хэлшинжлэлийн дэд эрдэмтэн Н.С.Яхонтова

Монголчуудын соёлын өв: гар бичмэл ба архивын баримтын цуглуулга

- IV. Олон улсын эрдэм шинжилгээний хурлын илтгэлүүдийн эмхэтгэл. Монгол улс, Улаанбаатар хот. 2019 оны 4 дүгээр сарын 18-19. Санкт-Петербург-Улаанбаатар., 2019 г. 276 тал.

Монгол улсын ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэн, Оросын ШУА-ийн Дорно дахины гар бичмэлийн хүрээлэн болон Олон Улсын Монгол судлалын холбооноос 2019 оны 4 дүгээр сарын 18-19-нд Монгол улсын Улаанбаатар хотноо “Монголчуудын соёлын өв: гар бичмэл ба архивын баримтын цуглуулга” 4 дэх удаагийн олон улсын эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулав.

ОХУ, Монгол улсын гар бичмэлийн сан хөмрөг, архивуудад хадгалагдаж байгаа монгол угсаатан ард түмнүүдийн түүх, хэл, соёлын арвин баялаг эх сурвалж нь тус хурлын эх суурь болсон юм. Эмхэтгэлд монгол судлалын түүх, дэлхийн ба Монгол, Оросын шинжлэх ухааны байдал, монголчуудын эдийн соёл, бичгийн өв, уран сайхны бүтээл туурвил, Монголын уламжлалт болон орчин үеийн нийгмийн асуудлыг тусгасан гар бичмэл, баримт, эх хэрэглэгдэхүүнийг судлан шинжилсэн илтгэлүүд багтсан болно.

ISBN 978-9919-9646-7-2

DOI 10.25882/z7ch-tr43

© Монгол улсын ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэн, 2021

© ОХУ-ын ШУА-ийн Дорно дахины гар бичмэлийн хүрээлэн, 2021.

© Олон улсын Монгол судлалын холбоо, 2021.

MONGOLIAN
ACADEMY OF
SCIENCES
Institute of History
and Ethnology



INTERNATIONAL
ASSOCIATION FOR
MONGOL STUDIES



RUSSIAN ACADEMY
OF SCIENCES
Institute of Oriental
Manuscripts



CULTURAL HERITAGE OF THE MONGOLS: MANUSCRIPT AND ARCHIVAL COLLECTIONS

IV

**International Conference
Under the Patronage of the President of Mongolia**



April 18-19, 2019. Ulaanbaatar, Mongolia

Proceedings

St. Petersburg — Ulaanbaatar
2021

ННА 63.4
ДAA 930.1
М-694

Managing Editor:	Academician S.Chuluun
Scientific Editors:	Dr.Sc. (Philology) I.V.Kulganek Ph.D (History) N.Khishigt
Editor, compiler:	Ph.D (History) B.Natsagdorj Cand. Sc. (Philology) N.S.Yakhontova

Cultural heritage of the Mongols: manuscripts and archival collections. Papers of the IV International Conference, April 18-19, 2019. Ulaanbaatar, Mongolia. St.Petersburg —Ulaanbaatar 2019, 276 pages.

This is a collection of papers, presented at the Fourth International Conference organized by the Institute of History and Archeology of the Mongolian Academy of Sciences, the Institute of Oriental Manuscripts of the Russian Academy of Sciences and the International Association for Mongol Studies which was held in Ulaanbaatar on April 18-19, 2019.

The basis for the conference was hand-written funds and archives, storing documents and materials on history, culture, ethnography, politics and language of the Mongolian peoples. The collection publishes reports on the history of Mongolian studies, as well as reports on handwritten material on the Mongolian culture, their written heritage, artistic creativity, expeditions and the problems of traditional and Modern Mongolian society.

ISBN 978-9919-9646-7-2
DOI 10.25882/z7ch-tr43

© Institute of History and Ethnology, MAS 2021
© Institute of Oriental Manuscripts, RAS 2021
© International Association for Mongol Studies, 2021

ГАРЧИГ / СОДЕРЖАНИЕ / CONTENT

Өмнөтгөл (С.Чулуун)	9
<i>Г.Ариунтуяа</i>	
Монгол Улсын Үндэсний Төв Архив дахь Ж.Цэвээний хувийн хөмрөг	11
<i>Д.Баярсайхан</i>	
Монголчуудын тухай XIII-XIV зууны Армян сурвалжийн тойм	23
<i>Ts.P.Vanchikova</i>	
Folklore Heritage of the Buryats in the Funds of the COMX and Problems of its Research and Conservation	35
<i>Ж.Гэрэлбадрах</i>	
Монгол Улсын Газар зохион байгуулалт, Геодези, Зурагзүйн газрын архивт буй нутгийн зургийн цуглуулга	43
<i>Л.С.Дампилова</i>	
Шаманские материалы в фонде Т.К.Алексеевой в ЦВРК ИМБТ СО РАН	57
<i>Ж.Долгорсүрэн</i>	
Эрдэмтэн, зохиолч, найруулагч, орчуулагч Э.Оюун: хэвлэгдээгүй гар бичмэл, намтрын баримтууд	65
<i>Г.А.Дыргеева</i>	
Традиционная письменная культура Бурят: социолнгвистический аспект	73
<i>Г.А.Гребенищикова</i>	
Монголия в планах Военного и Морского ведомств России в 1903-1913 годах	84
<i>В.Ю.Жуков, И.В.Кульганек</i>	
«История монголов» О.М.Ковалевского: первое прочтение	98
<i>И.М.Захарова, М.В.Мандрик</i>	
К вопросу о деятельности Советника при Монгольском правительстве П.А.Витте	107
<i>С.Мөнхсайхан</i>	
Уламжлалт монгол хэл зүйн бичгүүдийн хэл шинжлэлийн ач холбогдол хийгээд сурвалж бичгийн үнэ цэнэ	121
<i>Б.Нацагдорж</i>	
Тод үсгийн нэгэн захидлаас <i>Ойрад</i> хэмээх нэрийн тухай тодруулах нь	136

Д.А.Носов

Россыпи документов В.А.Казакевича: отчеты о поездках
по Монголии 1923—1925 гг. 149

К.В.Орлова

Документальное наследие калмыков: письма калмыцких ханов 160

Р.Ю.Почекаев

Суд и процесс в монгольских «Хождениях в ад» 167

Г.Сэр-Од

Монгол Улсын Үндэсний төв архивын сан хөмрөг дэх
Тамга, захирлага, тэмдгийн цуглуулга хөмрөг 176

М.В.Федорова

Монгольские фотоколлекции конца XIX — начала XX вв.
в собрании Российского этнографического музея, как источник
для изучения традиционной культуры монголов 186

Ц.Цэрэндорж

XV-XVIII зууны Солонгос сурвалж дахь Монголын түүхэнд
холбогдох мэдээ баримтаас 204

Д.Энхцэцэг

Монгол – Мингийн харилцаа: захидал бичгийн тухай 219

Ц.Энхчимэг

“Төмөрийн цаазын бичиг”: Монголын эзэнт гүрний түүхийн
чухал сурвалж болох нь 240

Н.С.Яхонтова

Аспиранты из Монголии в Академии наук 250

Сведения об авторах 268

Зохиогчдын танилцуулга 272

Д.Энхцэцэг

МОНГОЛ – МИНГИЙН ХАРИЛЦАА: ЗАХИДАЛ БИЧГИЙН ТУХАЙ¹

DOI 10.25882/c5ej-k752

Эзэнт гүрний дараах үеийн Монголын түүх, ялангуяа Монгол-Мингийн харилцааны түүхийг дахин судлан үзэж, энэхүү харилцааны онцлогийг нээн илрүүлэх нь чухал байна. Үүнд, Хуа-и Июй толь, Мин улсын судар, Мингийн магад хууль зэрэгт хятад үсгээр монгол хэлээр тэмдэглэгдэн үлдсэн бичгүүд чухал сурвалж болно. Хоёр улсын харилцаа нь нэг хуридаж, нэг намдаж хүчний харьцаа өөрчлөгдөхийг дагалдан хувьсан өөрчлөгдөж байжээ. Монголын хаадын Хятадад илгээсэн бичиг захидлын уг эх, хуулбар, орчуулга сэлт нь одоогоор илэрч олдоогүй боловч элч нарын тухай тэмдэглэл өдий төдий байна. Мин улс нь бууж өгсөн монголчуудыг Монголд элч болгон томилж илгээдэг байсан бөгөөд хариуд нь монгол ноёд тэдгээр элч нарын хамт өөрсдийн бичгийг илгээдэг байжээ. Түмэдийн Алтан хааны үеэс эхлэн төвд болон хятад үсгээр мөн бичиж бичиж илгээх болсон байна. Элч нарын авчирсан монгол үсгийн захидлыг Харийн орчуулгын товчоонд өгч хятадаар орчуулгаад дээд захиргаанд дамжуулан өгдөг. Энэхүү орчуулгын албанд харийн хэл мэдэх хүнийг сонгон шалгаруулж аваад улмаар орчуулгын эрдэмд сургадаг байжээ. Монгол хаад ноёдын Мин улсад илгээсэн бичиг захидал хэзээ нэг өдөр олдох байх хэмээн найдаж байна.

Түлхүүр үгс: Эзэнт гүрний дараах үе, монгол хаад, Мин-Монголын харилцаа

D.Enkhtsetseg

MING-MONGOLIAN RELATIONS: ON THE CORRESPONDENCE BETWEEN TWO STATES

Many aspects of post-imperial history need to be re-examined, including the Mongol-Ming embassy - correspondence between them. It is important to

¹ ӨМӨЗО-ны Шилийн хотын Түүх соёлын дурсгалыг хамгаалах газрын ажилтан Айзам Мин ши лү (明实录) зэрэг хятад сурвалжийн мэдээг орчуулж, хамтран бэлтгэсэн болно.

clarify the specifics of the correspondence between the Mongolian state and Ming and how the wording has changed and to study this in depth in the future, based on Mongolian historical texts and historical documents such as the Hua-yi Yi-Yu Dictionary, Ming Shi, Ming Lu Xi, and Ming shilu written in Chinese characters in Mongolian. The relations between the Mongol and Ming states have been sometimes slowing down, and sometimes expanding over the course of history due to state policy and power relations. The originals, copies and original translations of the letters of the Mongol khans to Ming are not yet available, but we still have a lot of messages sent by envoys and letters. The discovery of the sources of original letters and writings in these sources, which are intended to clarify on the history of bilateral relations will be a new area of research. The Ming dynasty used the remaining and surrendered Mongols as ambassadors to Mongolia. Mongol khans and princes wrote letters of expressing their intentions in Mongolian and sent them through envoys. From the time of Altan Khan of Tumed, their letters were sent in Tibetan and Chinese. The Mongolian letter sent by the envoy was translated into Chinese by the Department for Foreign Language Translation of Ming State and submitted to the top management. The Department of Foreign Translation (四夷馆) was an organization that recruited, trained, and employed people who knew foreign languages and had the ability to translate. For many years, they selected interpreters who were fluent in foreign languages and trained foreign language translators and interpreters. From the Ming State, prepare awards and letters of appreciation for Mongolian khans, princes, queens, and nobles and will be sent as envoys. We believe to find the originals, copies and original translations of the letters of the Mongol khans.

Keywords: *Post-imperial period, Letters of Mongol khans, Ming-Mongol relations.*

XIV зууны эцсээр хятад дахь ноёрхол халагдан, эх нутагтаа ирснээр Монгол улсын дотоод, гадаад байдал түгшүүртэй, зөрчил тэмцэл дайн тулаан олширсон ч элчин харилцаа төрийн гадаад бодлогын хувьд ихээхэн үүрэгтэй хэвээр байжээ. Монголын хаад, ноёд хөрш зэргэлдээ улстай харилцан цэрэг – улс төрийн дэмжлэг авч өрсөлдөгч талын хүчийг сулруулах, нэгэн зэрэг хэд хэдэн чиглэлд дайтахаас зайлсхийх гол арга нь болж байсан. Монголчууд худалдааны зам харгуйгаас алслагдан, эдийн засгийн хэрэгцээ шаардлагаас үүдэн Алба өргөн арилжаалах шинэ хэлбэр үүссэн нь Монгол болон Мин хоёр улсын элчин харилцаанд

тэргүүлэх байр суурьтай болсон. Монгол орон том, жижиг олон эзэмшил болон задарч, Монголын хаад, ноёд өөр өөрийн нэрийн өмнөөс элч илгээн хөрш улстайгаа харилцах болсон нь энэ үеийн гадаад харилцааны бас нэг онцлог юм.

Эзэнт гүрний дараах үеийн түүхийн олон асуудал түүний дотор Монгол – Мин хоёр улсын элчин харилцаа, харилцан уламжилсан анхдагч сурвалж - захидал бичгийг улируулан судлах шаардлага зүй ёсоор гарч байдаг. Монголын түүхийн зохиолууд, монгол хэлээр хятад үсгээр бичгээр тэмдэглэгдсэн захидал бичиг Хуа-и И-юй толь (华夷译语)²-толь бичгийн (1389 он) дэд дэвтэр болон Мин ши (明史); Мин ши лү (明实录); Ваньли-гийн оны тэмдэглэл (万历武功录), Мин улсын үед үүссэн хэрэг явдлын эх адгийг тэмдэглэсэн түүх (明史纪事本末), Мин улсын хууль зүйн тэмдэглэл (明会典), Жу Юаньжан-ы үеийн тэмдэглэлүүд (朱元璋系念要录)³ зэрэг нь хоёр улсын элчин харилцаа, харилцан уламжилсан захидал бичиг судлалд гол хэрэглэгдхүүн болно. Монгол - Мин хоёр улсын элчин харилцааны бичиг захидлын онцлог, төрөл, хэлбэр маяг, үг хэллэг хэрхэн өөрчдөгдөж ирсэн, гадаад харилцааны асуудал хариуцсан байгууллага ялангуяа орчуулан үйлдэх газар зэргийн талаар тодруулах, хойшид энэ талаар гүнзгийрүүлэн судлах нь чухал юм.

Эзэнт гүний дараах үеийн Монгол улсын гадаад харилцааны түүхэнд холбогдох захидал бичгийг:

- Мин улс - Монгол ноёд түшмэдийн харилцаанд холбогдох
- Монгол хаад ба Мин улсын харилцааны захидал бичгүүд гэж хоёр ангилж болно.

Мин улс - Монгол ноёд түшмэдийн харилцаанд холбогдох судалгааны бүтээл харьцангуй элбэг, харин Монгол хаадын Мин улстай харилцсан захидал бичгийн судалгаа ховор ажээ. Монгол хаад ба Мин улсын харилцаа Мин улс байгуулагдахын өмнө эхэлсэн. Улаан алчууртаны бослогын удирдагч Жу Юаньжан [1367 оны] *есөн сарын шар нохой өдөр* [9.28] *Юань гүрний эзэнд элч томилон захиа илгээ[жээ]*⁴. Босогчид [1368.1.28] Жу Юаньжаныг Хун-Ү (1368 – 1398)

² Нангиад Монгол Хуа-и и-юй толь, латин галиг хийж, шинэ үсэгт хөрвүүлсэн С.Жанчив, Ц. Бямбацэнд УБ. 2005; Ө.Мандах Монгол И-юй бичиг. Хөх хот. 1995.

³ Мин ши (明史) 中华书局. 1974, Мин ши лү (明实录).... Ваньли хаан оны тэмдэглэл (万历武功录). 中华书局. 1962; -Мин улсын хууль зүйн тэмдэглэл (明会典) 中华书局., 1989; Мин улсын үеийн хэрэг явдлын эх адгийг тэмдэглэсэн түүх (明史纪事本末)中华书局. 1977.

⁴ Мин улсын судар: Тайзү хааны уг тэмдэглэл. Эртний хятад хэлнээс орчуулж, оршил

хуанди өргөмжлөн улсын нэрийг Мин, хааны цолыг Тайзү (太祖) хэмээн нэрлэжээ. Энэ үеэс Монголын Юань улс, Хятадын Мин хоёр улс зэрэгцэн оршиж хоёр улсын элчин харилцаа жинхэнэ утгаараа эхэлсэн. 1368 оны намар босогчид нийслэл орчмыг довтлон *Намрын илүү [долоон] сарын улаан барс өдөр* [9 сарын 10]⁵ Тунжөү-г эзлэхэд Юань улсын хаан Тогоонтөмөр (1333-1370) албат олноо дагуулан Хаанбалиг [Дайду] нийслэлээ орхин гарч, Шанду, Инчанфу-гаар дамжин өвөг дээдсийн төр улсаа мандуулсан нутагтаа иржээ. Мин улсын эхний үед монголчуудыг илбэн тохинуулах, ухуулан дагуулах, хил хязгаар нутгийн ард иргэдийг дотогш нүүлгэн шилжүүлэх, аж ахуйн талаар арилжаа худалдааг чандлан хязгаарлах, цэрэг зэвсгийн хүчээр сүрдүүлэх зэрэг харилцан уялдаа бүхий бодлого баримталж байжээ.

Хун Ү-гийн хоёрдугаар оны найман сард Мин улсын Тайзү хуанди Инчанфу-д сууж буй Тогоонтөмөрт *элч илгээн ... захидал*⁶ хүргүүлсэн нь хоёр улсын төрийн элчин харилцааны эхлэл болсон. Мөн оны найман сард Тогоонтөмөр хаанд элч илгээн захидал хүргүүлжээ. Захидалд... Мөхөс би болвоос угаас харц хүн болой. Ойрд улсын дотоодын байдал тогтворгүй, үймээн самуун ихтэй болов. Олон газар орны эмх замбараагүй бослого, хулгайг дарж, ард иргэдийг амартүвшин болгохыг бодох нэг ч хүн үгүй болжээ. Иймээс ... биеэрээ жанжидаа дагуулан ... найман хаалга, хоёр мөрнийг өөрийн харьяат нутагт оруулав. Гэтэл эрхэм та улсынхаа төлөө санаа тавихгүй өөр хоорондоо алалдан тэмцэлдэж, ард иргэдийг зовлонд учруулсан ажгуу. Иймээс уржнан жил их жанжидаа Шандун, Хэнань, Тунгуань, Дайдао [Дайду] зэрэг газарт илгээв ... миний цэрэг хүрч очоогүй атал эрхэм та өвөг дээдсийн орд харшийг орхиод нэгэнт буруулан явсан байлаа. Миний бодоход монголын зуу хүрэхгүй жилийн хувь заяа дууслаа гэдгийг ухааран мэдээд, тэнгэрийн тааллыг дагаж хятадын хуучин нутгийг буцаан өгч байгаа гэж машид сайшааж байв. Гэтэл удсангүй эрхэм та Кайпингийн зүг[ээс] байн байн уулгалан довтлох болов хэмээн харуулын сэргийлэх жанжид илтгэн мэдээлэх болов. Эрхэм та урьд өмнө орд харш амгалан, улс гүрнээ чинээлэг байх үед тэр олон дээрэмчдийг дарж чадаагүй байж, одоо говьд очоод ... байн байн хил рүү аюул учруулж байгаа нь эрхэм таны алс хэтийг бодохгүй, ухвар мөчдийн [хэрэг] биз ээ. Одоо

тайлбар хийсэн Д.Ундрах, Ч.Содбилэг. УБ. 2017, 33.

⁵ Мин улсын судар. Уг тэмдэглэл. I - XII дэвтэр. Эртний хятад хэлнээс орчуулсан Д.Ундрах, Ц.Цэрэндорж, Ч.Содбилэг. УБ. 2018, 46.

⁶ Мин улсын судар. Уг тэмдэглэл. I-XII дэвтэр. УБ. 2018, 50.

хятадын бүх нутаг миний эрхэнд орж, орон даяар ... харь угсаатан цөм захирагджээ. Хэрэв би умард этгээдэд цэрэг гарган довтлон ... чигээрээ Иншань уулын умар зүгт хүрээд очвол эрхэм танд хэдийгээр хэдэн түмэн иргэн байлаа ч ... үнэн хэрэгтээ унтарч байгаа галын цог, ус нь хатсан голын загас мэт болохоор яахан ийнхүү аашилж болох билээ. Эрхэм та хэдийгээр умарт этгээдэд зугатан одсон ч танд цааш очих газар даанч байхгүй биз ээ. Миний бие эрхэм таныг байдлыг өөрчлөн, хувь заяагаа шийдэж, үг дуугүй дагавал сая удам угсаагаа хамгаалж чадна гэдгийг чин үнэн санаанаасаа зөвлөө. Та үүнийг сайтар тунгаан соёрхоно уу⁷ хэмээгээд

君其奉天道，顺人事，遣使通好，庶几得牧养于近塞，藉我之威，号令其部落，尚可为一帮之主，以奉其宗祀。若计不出此，犹欲以残兵出没为边患，则予大举六师，深入沙漠，君将悔之无及矣⁸ - Эзэн та тэнгэрийн санааг дагаж, хүний жамыг журамлаж, элч илгээн харилцаа тогтоовол ардууд чинь хилийн ойрхон мал маллан, [та] миний эрх сүрийн доор өөрийнхөө харьяат олныг захирч эзэн нь сууж болно. Хэрэв эс бөгөөс хил хязгаарт халдах аваас их цэргээр дайрч, эзэн та хязгааргүй харамсах болно гэжээ.

Мин улсын хаан ёс журмыг сахисан мэт боловч монголчуудыг Дайдугаас гаргаж цэрэг улс төрийн амжилт олсон тул ихэд бардам, сүр далайлгасан нь илэрхий. Их Юань улсын хааныг дагаар ирэхийг ч шаардахаа мартсангүй. Тогоонтөмөр хаан хүлээж авсангүй, Дайдуг эргүүлэн авахын төлөө бүхий л арга хэмжээг авч байв.

Хун Ү-гийн хоёрдугаар оны өвлийн тэргүүн сард Юань улсын эзэнд [Тогоонтөмөрт] *элч зарж захидал хүргүүлэв*⁹:

改图易虑，安分顺天，保境土以存宗祀。若欲效汉之匈奴，唐之突厥，出没不常，以为边患，是计之不审也。¹⁰ - Санаа бодлоо өөрчлөн, тэнгэрийн санааг даган, нутаг дэвсгэрээ сахиж, дээдийн удмаа үлдээ. Хэрэв Хүннү ... мэтийг дууриаж, хилийг үймүүлбэл лавтай нэхэмжилнэ гэсэн санаагаа илтгэжээ.

⁷ 明史纪事本末，中华书局，1977；Идэр Д. Их Юань улс (1368-1388) II, УБ. 2013, 110 -111.

⁸ 明太祖实录 (Мин Тайзү шилү), 洪武二年八月己丑 (Хун Ү-гийн хоёрдугаар оны найман сарын шаргачин үхэр өдөр).

⁹ Мин улсын судар. Уг тэмдэглэл. I-XII дэвтэр. УБ. 2018, 50.

¹⁰ 明太祖实录 (Мин Тайзү шилү), 洪武二年十月辛卯 (Хун Ү-гийн хоёрдугаар оны арван сарын цагаагчин туулай өдөр).

Тогоонтөмөр хааны ХХХ [1370] оны [зуны] тэргүүн сарын шинийн хоёрны өдөр *Эзэн хааны бие чилээрхэн, Жуу бичиг буулган Хунтайж [Аюуширидара]-ийг төр, цэргийн хэргийг ерөнхийлөн хамаарагтун*¹¹ хэмээн, хааны эрх мэдлийг шилжүүлжээ. Мөн сарын улаан нохой өдөр¹² Тогоонтөмөр хаан түр нийслэл Инчан хотод таалал төгсчээ. Мин улсын Тайзү хаан элч томилон илгээсэн, эмгэнэлийн бичигт:

Үхэх төрөх, мандах мөхөх гэгч нь нэгэн цагийн гэнэтийн тохиол бус, тэнгэр гэзрын тогтоосон таалал буюу. Эртний багш мэргэд хэмээгдэгсэд ч гэсэн энэ дөрөвийн нэгэнд нь харгахын тулд, эс хувирах хэмээж яахин болох ажээ? Үүнийг нь тэнгэрийн зарлигийг мэдсэн ахул эс сэжиглэмүй хэмээх болой. Юань улсын эзэн хаан таны өвөг дээдэс эрт үед говь элсэн газраас мандаж, нум татаж, зэв харваж манай Дундад оронд ороод дэлхий дахиныг эрхшээж, таван өнгө, дөрвөн харийг хураан тогтоосон нь тэнгэрийн зарлиг бус болбоос хэрхэн ийм болох аж. Эзэн хаан таны эцэг хөвгүүд чив хэмээн нимгэн хувцсаар хотоо сахих цагт хулгай дээрэм Рү, Ин зэрэг газраас босч. Хуашя орныг доргиож, захиа зарлиг эс явагдан улс орноо алдсан байлаа. Үүнийг хүний үйл хэмээн буюу? Мөхөс би тэр цагт дэлхий дахиныг сүрдүүлэх хуяг зэвсэг эс агсан атал, мөн эзэн хаан таны төр гүрнийг оруулан захираад иргэдийн төлөө эзэн болсон нь бас ч тэнгэрийн зарлигаар болсон нь энэ болой. Эгнэгт хаан та бээр говь элсэн газрыг эрхшээж, эзэн би Дундад орноо захирсугай. Хаантан та түшмэдтэйгээ хамт хүсч сүрээ хөдөлшгүй бэхжүүлээд зах хязгаарыг минь цочоон хэдэнтээ мандсан бүлгээ. Эдүгээ хаан таныг говь элсэн газарт хальсаныг сонсоод эзэн миний бие машид эмгэнэн гашуудмуй. Онцгойлон элч томилон гашуудаж хүндэтгэл болгон илгээсэн сархадын тахилгыг минь таны сүнс амсан соёрхож, гэгээндээ толидох ажааму¹³ хэмээжээ.

Тогоонтөмөр хааны үеийн Монгол - Мингийн харилцаа нь *Эгнэгт хаан та бээр говь элсэн газрыг эрхшээж, эзэн би Дундад орноо захирсугай* хэмээн хоёр улс өөр өөрийн газар нутаг, ард олноо захиран суух болсон гэдгийг хүлээн зөвшөөрсөн байна. Ийнхүү Тогоонтөмөр хааны үеэс Монгол - Мин хоёр улсын элчин харилцаа албан ёсоор эхэлж, түүхэн цаг үеийг уртад нэг саарч, нэг өргөжсөөр Лигдэн хааны үе хүртэл үргэлжилсэн түүхтэй. Монгол - Мин хоёр улсын элчин харилцаа түүхэн цаг үеийн хоёр улсын төрийн бодлого, хүчний харилцаа зэргээс шууд шалтгаалж байсан.

¹¹ Умар газар одсон хувийн тэмдэглэл. УБ. 2016, 19.

¹² Мин улсын судар. Тайзү хааны уг тэмдэглэл. УБ. 2017, 51.

¹³ 明史纪事本末, 中华书局, 1977; Идэр Д. Их Юаны улс. УБ. 2013, 110.

Аюуширидара хаан Хархорумд ирж *Улсыг дахин сэргээн мандуулах* оны цол зүүж, монголчуудын цэргийн хүчийг нэгтгэн хятад дахь ноёрхлоо сэргээх, төр, цэрэг, иргэний асуудал хариуцсан яам байгуулан, тамга тэмдэг цутган, түшмэдийг томилон цол хэргэм олгож, эрдэмт мэргэд, өрлөг сайдаа цуглуулан, улсын үйлийг эрхлүүлэх болсон. Мин улсаас алс хол Монголын хаанд элч томилон илгээх болжээ. Анх 1370 оны 11 сарын 14 [өвлийн тэргүүн сарын цагаан могой өдөр], 12 сарын 26 [өвлийн сүүл сарын харагчин гахай өдөр]¹⁴ тус тус Юань улсын угсаа залгамжилсан эзэн Аюуширидара хаанд элч томилон захидал хүргүүлж, Мин улсыг дагахыг ятган сануулжээ.

1371[2] онд элч илгээн... урьд хоёр удаа элч томилон захидал илгээсэн, хариу одоо хүртэл сураг чимээгүй болой. Тунгаан үзвэл эрхэм таны ухвар мөчид бодлогоос болжээ. Эрхэм таны санаа бол тэнгэрийн доорх эзэн нь би болохоор түүний доторх ард иргэд бас минийх байх ёстой хэмээн үзэж амуй. Гэтэл ёс журмын дагуу хэлэлцвэл тийм биш ажай эртний үгэнд ард бол ус, хаан бол завь, ус бол завийг дээш хөвүүлж чадна, бас хөнтрүүлж ч чадна гэж хэлдэг. Гэтэл эрхэм та үүнийг ойлгохгүй, эрэгцүүлэн ухаарахгүй зөрүүд зан гаргаад юунд эс буцаж ирнэм. Эдүгээгийн хэрэг явдлаар үзэхэд эрхэм таныг түших баатруудын байгуулсан гавьяа өчүүхэн ч алга. Миний цэрэг өөдрөөс өдөрт хүчирхэгжин байхад эрхэм та хуучин байдлаараа байхыг хэрхэн зөвшөөрөх ажээ. Эзэн тэнгэрээс нэгэнт заяаж хайрласан эдүгээгийн байдлыг хэрэн дур зоргоор өөрчлөн шийдэх билээ. Эрхэм минь юунд зальхай этгээдүүдийн үгэнд орж, гуньж гомдон суунам. Даруй эв найр тогтоож, тэнгэрийн ёсыг таалж, хүний ёсыг дагавал эрхэм таны харьяаны аймгуудад манай зарлиг хүчин төгөлдөр болох биш үү. Тэр цагт эрхэм та миний гүрэн улсын дотор эзэгнэн захирсан нэг эзэн нь болж, өвөг дээдсээ хүндлэн тахиж явах эрхтэй үлдэнэ. Хэрвээ энэхүү байдлыг үл хайхран үлдсэн цөөхөн цэргээрээ хил хязгаарыг довтлон үймүүлэх аваас өөрт чинь аюул нүүрлэнэ. Би зургаан их жанжныхаа удирдсан цэргийн бүх хүчийг говь нутагт хөдөлгөн оруулах болно. Тэрхүү цагт эрхэм та харамсал илэрхийлэн гуйвч цаг нэгэнт оройтсон байх болов уу¹⁵ гэж Мин улсын бодлого, ялсан эзний сүр хүчийг үзүүлэх хандлага давамгайлсан захидалд Монголын хаан, хариу илгээсэнгүй.

¹⁴ Мин улсын судар. Уг тэмдэглэл. I- XII боть. УБ. 2018, 52.

¹⁵ 明史紀事本末, 中华书局, 1977. Идэр Д. Их Юаны Улс. УБ. 2013, 111.

[1374 онд] Аюуширидара хаанд дахин нэг удаа элч илгээн: 若能悟我所言, 必得一族于沙漠中暂尔保持, 或得善终。君若不悟, 他日加兵于彼, 祸有不测者矣¹⁶ - хэрэв миний хэлснийг зөвшөөрөх [аваас] говь нутагтаа [Монгол нутагт] аймаг олноо захирч суух эрх мэдлийг, хэвээр нь байлгах буюу нэн сайн үр дүн олж чадна. Хэрэв та үл ойшоох болвоос аль нэг өдөр их цэргээр дайдж, гай зовлон тарих болно

гэж ятгах, сүрдүүлэхийг зэрэгцүүлэн элчин томилж бичиг илгээж байжээ.

Удалгүй элчин харилцаа тасарч, дайн тулаан эхэлсэн. Элчин харилцаа, цэрэг дайны бодлого тухайн улс түмний гадаад харилцаа, төрийн гадаад бодлогын хоёр тал, нэгээс нөгөөг нь салгах аргагүй, харилцан бие биеэ нөхвөрлөнө. Шюй Да тэргүүтэй их цэрэг гурван зам хуваан Монголд довтолж, Монгол - Мингийн дайн өрнөжээ. Гэвч цэрэг ялагдан, Мин улсын цэргийн бодлого, аян дайн амжилт олсонгүй, Ляодунд монголчуудын хүч нөлөө нэмэгдэн, Монгол – Корйө-гийн харилцаа сэргэж, Мин улс цэрэг зэвсгийн хүчээр монголыг мөхөөх боломжгүй зэргийг харгалзан, өөр хооронд нь зөрчилдүүлэн хүчийг сулруулах эртний уламжлалт бодлогод шилжиж, найрсаг харилцаа тогтоохыг чухалчилжээ. Үүний тод илрэл нь Аюуширидара хааны хөвүүн Майдарбалыг буцаасан хэрэг явдал юм. Бар жил [1374.10.20] Мин улсын хуанди, хятадад олзлогдсон хүү Майдарбал [Чун-ли хөу (崇礼侯)]¹⁷-ыг нь эцгээ ятган, эвсэх явдлыг дөхөм болгох, монголын дотоод хэрэгт оролцуулахаар ёс журмыг баримтлан Юаньбуха, Төмөр хоёр түшмэлийг бэлэг сэлтийн хамтаар томилон¹⁸ Аюуширидара хаанд захидал илгээн ... урьд [Аюуширидара хаан] эрхмийн Инчан хотод орхисон балчир үрийг чинь би өмнөд газарт авч ирүүлээд ихэд хүндэтгэлтэйгээр харгалзаж, таван он шахам болов. Эрхэм та ... говь нутгаар хэсүүчлэн ... эцэг хүү хоёр хагацаж, удам залгуулах хөвгүүн үгүй ихэд зовж байгааг ойлгоод ... [Майдарбал]-ыг хойд зүг буцаах болсон¹⁹... Их Юань улсын удам угсааг тасалдуулахгүй залгамжлуулахыг бодсон бүлгээ. Эрхэм та

¹⁶ 明太祖实录 (Мин Тайзү шилү), 洪武七年九月丁丑 (Хун Y-гийн долдугаар оны есөн сарын улаагчин үхэр өдөр).

¹⁷ Гомбожав. Гангын урсгал. Монгол түүхэн сурвалж бичгийн цуврал. X боть. УБ. 2006, 17.

¹⁸ 明太祖实录 (Мин Тайзү Ши лү), 洪武二年四月乙亥 (Хун Y-гийн долоодугаар он есөн сарын улаагчин үхэр өдрийн зурвас).

¹⁹ Мин улсын түүх. Эртний хятад хэлнээс орчуулж, тайлбар хийсэн Н.Ариунгуа. УБ. 2015, 17.

энэ бүхнийг сайтар тунгаан соёрхоно уу²⁰ гэжээ. Мин улс байгуулагдсан эхэн үеийн хоёр улсын хаадын элчин харилцаан дахь Мин улсын баримтлах бодлого, арга хандлага адил илбэн дагуулах бодлого зонхилж, нэг талаар уран үгээр ятгаж, нөгөө талаар басамжлан тандах, цэргийн хүчээр сүрдүүлэх аргыг хослуулан хэрэглэж байсан нь илэрхий, энэхүү бодлогыг хүлээн зөвшөөрөх боломжгүй тул Монголын хаан элчийг буцаахгүй, өөрийн элчээ илгээж харилцсангүй.

1378 оны зуны тэргүүн сард Монгол улсын Аюуширидара хаан таалал болжээ. Мин улсаас *XI оны ... зуны сүүл сарын хар хулгана өдөр [1378.7.6] элч илгээж, урьдын Юань улсын угсаа залгамжилсан эзэнд тахилга*²¹ өргүүлжээ.

1379 онд Төгстөмөр (1379-1388) хаан өргөмжлөгдөн, Усхал хэмээн алдаршсан. Төгстөмөр хаан Хархорум, Барс хот, Инчаныг холбон их цэрэг хуримтлуулан, Өлзийбуха, Найрбуха, Манз, Харажан, Лай эр, Тогооч, Азу [Айзү] Нагачу зэрэг түшмэд, жанжид харьяат цэргийн хүчээр Ляодун хүртэлх өргөн уудам нутгийг сахин ... Инчан, Хоринд олныг хамгаалж, үе үе боомтын доор [умар хязгаарт уулгалан] нэг үзэгдэн, нэг алга болж бай[в]. Мин улсаас Төгстөмөр хаанд элч илгээн олонтаа тамга бичиг шагнан, аргадсан боловч огт дагасангүй²² хоёр талын элчин харилцаа саарчээ.

Усгал хаанаас хойш монгол оронд засаглалын хямрал гүнзгийрч, зөрчил тэмцэл олширсон. Төр засгийн эрх мэдэл суларч, орон нутгийн язгууртнууд толгой өндийлгөж, хаад эрх мэдэл үгүй, түргэн солигдож, нэр цолыг ч таах арга үгүй болжээ. Мин улсын түүхэнд Хун –Ү (1368-1398)-гийн XXII [1389] онд Юань улсын Есүдэр өөрийн эзэн Төгстөмөрийг хороож[ээ] хэмээгээд *Мин улсад элч илгээсэн алба барьж байсан гадаад улсуудын тэмдэглэлд түүний тухай дурьдсан байдаг. Дотоодын зөрчил, Мин улсын довтолгоо зэргээс үүдэн 1388-1394 онд Зоригт (1388-1391) болон Энх (1391-1394), Элбэг (1394-1399) хаад байр сууриа бэхжүүлж чадсангүй. Мин улстай элч, захидал илгээн харилцсан мэдээ үгүй.*

Элбэг хааны ахмад хүү Гүнтөмөр [Тогоон] (1399-1402) хаан ор залгамжлан суусан. Мин улсын магад хуульд:

²⁰ 明史纪事本末, 中华书局, 1977. Их Юань Улс. УБ. 2013, 112.

²¹ Мин улсын судар. Уг тэмдэглэл. I-XII боть. УБ. 2018, 62.

²² Мин улсын түүх. УБ. 2015, 18; Мин улсын судар. Олон шастир. 327 дугаар дэвтэр. Татар. Эртний хятад хэлнээс орчуулсан Д.Ундрах, Ц.Цэрэндорж, Ч.Содбилэг. УБ. 2018, 129.

[1399 онд] Мин улсын шинэ хуанди Хуйзун [Жу Юньвэнь (1398 -1402)]... нэгэнт хаан орыг залгамжлав ... элч илгээн Хархорум, Ойрад зэргийн ахлагчид жуу бичиг хүргүүлж²³ харилцжээ. Жу Юньвэнь (1398 -1402) гуравдугаар оны [1401 он] 11 сард ...鞑靼可汗遣使来谕款²⁴ - Татарын хаан элч ирүүлжээ [хэмээсэн нь он цагийн хувьд Гүнтөмөр хаан Мин улстай элч илгээн харилцсан тухай баримт болно]... [1401 оны 11 сард] Татарын хаан элч ирүүлж, шудрагаа илтгэжээ²⁵ ... Төгстөмөр [хаан]-өөс хойш аймгийн тэргүүлэгчид харилцан самуурч, таван үе уламжилсны дараа Гүнтөмөрт хүрч ирээд бүгд бусдын гарт амь үрэгдсэн учир хааных нь цолыг үл мэдмүй, Гүнтөмөр хүртэл зургаан хүн хаан ширээ залгамжилсан ч бүгд алагдаж тэдний нэг нь ч оны цол хэрэглээгүй²⁶

хэмээн цухас мэдээ үлджээ.

Мин Юнлө (1403-1424) хуанди Монголын хаан, тайшид тус тус элч томилон зүүн, баруун Монголын зөрчлийг ашиглан, улс төр, аж ахуй, цэрэг дайны арга бодлого хэрэгжүүлж, хүч буурайг нь дэмжин хүчин нь их талыг дарангуйлж, харилцан тэмцэлдүүлж бие биеийн хүчийг сулруулахыг санаархаж байсан нь энэ цаг үеийн хоёр улсын элчин харилцааны гол онцлог болжээ. Монгол - Мингийн 30 гаруй жилийн дайн тулааны сургамж монголчуудыг мөхөөх нь хялбар биш болохыг Мин улсад ойлгуулжээ. XV зууны эхэн үеийн Монголд илгээсэн бичиг захидлын үг хэл, хэллэг өөрчлөгдөн тухайлбал:

作宾吾朝 - манай төрд зочлох, 安分顺天 - биеэ мэдэж тэнгэрийн санааг дагах, 归降 - дагаар бууж өгөх гэх зэргийн үгс харагдахаа больсон. Харин, 今天下大定, 薄海内外皆来朝贡。可汗能遣使往来通好, 同为一家人, 使边城万里烽喉无警, 彼此熙然, 共享太平之福 - эдүгээ тэнгэрийн доорх байдал нь нэгэнт тогтов. Ойр хавийн улсууд цөм биднийг дагасан байна. Хаан та элч илгээж, найрамдал байгуулбал бид бүгдээр нэг гэр болж, хилийн орчмын хот суурин дайн дажингүй, харилцан эв найртай, хамтдаа амар тайвныг эдлэе

²³ 明太宗实录 (Мин Хуйзун шилү), 洪武三十五年八月丁丑 (Жу Юньвэнь-ий тэргүүн оны найман сарын улаагчин үхэр өдөр).

²⁴ 明太祖实录 (Мин Хуйзун шилү), 建文三年十一月辛亥 (Жяньвэнь гуравдугаар оны арван нэгэн сарын цагаачин гахай өдөр)

²⁵ 明太祖实录 (Мин Хуйзун шилү), 建文三年十一月辛亥 (Жу Юньвэнь-ий гуравдугаар оны арван нэгдүгээр сарын цагаачин гахай өдөр).

²⁶ Мин улсын судар. Олон шастир. 327 дугаар дэвтэр. Татар. УБ. 2018, 134; Мин улсын түүх. УБ. 2015, 21.

гэх мэтээр өгүүлэх болжээ.

1403 онд Аругтай [зарим нь Үгэчи хашиха гэх], Гүйличийг тэтгэж хаан ширээнд суулгаж, эрх мэдлийг төвлөрүүлэхийг оролджээ. Монгол - Ойрадын хямралын үед Элбэг хааны хүү Өлзийтөмөр [Буняшир] Дундад Ази, Цагадайн улсад хүн ард, цэрэг морио амраан Бэшбалигт түр суужээ. 1403 онд Доголон Төмөр эмир (1370-1405)-ийн дэмжлэгтэй *Юаны удмын Буяниширыг* [Буняшир] *Бэшибалыгт хаан ор суулгав*²⁷ хэмээн тэмдэглэжээ. Ийнхүү 1403 оноос хоёр хаан сууж засаглалын хямрал туйлдаа хүрсэн түгшүүртэй цаг үед, Мин Юнлө (1403-1424) Гүйлич хаан (1403-1408) болон Буняшири хаан (1403-1410)-д тус тус элч илгээн харилцаж байжээ. Тухайлбал:

Юнлө (永樂) (1403-1424)-гийн тэргүүн он. Хаврын дунд сард Гүйличийн илгээсэн элчийг нэвтрүүлэхийг зөвшөөрөн элч илгээн сайнаар харилцахыг аргадан ухуулж, мөнгө торго шагнаж, түүний жыюань Аругтай, чөншян Мархасан нарт бас [шан харамж] шагнаж²⁸ хариу захидал илгээж ... 宣示朝廷礼待远人之意。²⁹ - Мин улсын төрөөс холын хүнд ёс журамтай хандана ... эдүгээ тэнгэрийн доорхи байдал нэгэнт тогтнов. Ойр хавийн улсууд цөм биднийг дагажээ. Хаан та элч илгээж, харилцвал бид бүгдээр нэг гэр болж, хилийн хот суурин дайн дажингүй, харилцан эв найртай, хамтдаа амар тайвныг эдлэе³⁰

гэх мэтээр өгүүлэх болсон байна.

Гүйлич Мин улсын элчийг барьж хориод Мин улстай харилцахгүй болсон тул 1406 оны гурван сард Мин Юнлө хуанди Ха Шянь [Хашин] (哈先) нарыг Монголд илгээж, элчийг хорьж буцаахгүй байхын хорыг уршгийг ухуулан, хоёр тал эв найртай явахыг уриалжээ. Гүйлич хариу өгсөнгүй. Дараа жил нь [1407 он] Гүйличид илгээсэн бичигт:

前遣使致书可汗, 本期通好, 共享太平, 乃拘留信使不报。今再遣百户早花等审求其故, 祸福之机天有显道, 惟可汗省之。³¹ - урьд өмнө хаанд удаа

²⁷ Мин улсын түүх. УБ. 2015, 21.

²⁸ Мин улсын судар. Олон шастир. 327 дугаар дэвтэр. Татар. УБ. 2018, 135.

²⁹ 明太宗实录 (Мин Тайзун шилү), 永乐元年正月己未、七月庚寅, 三年十二月乙亥 (Юнлө-гийн анхны оны нэг сарын шарагчин хонь өдөр, долоон сарын цагаан бар өдөр, гуравдугаар оны арван хоёр сарын хөхөгчин гахай өдөр)

³⁰ 明太宗实录 (Мин Тайзун шилү), 永乐元年正月己未、七月庚寅, 三年十二月乙亥 (Юнлө-гийн тэргүүн оны нэгдүгээр сарын шарагчин хонь өдөр; долоон сарын цагаан бар өдөр; гуравдугаар оны арван хоёр сарын хөхөгчин гахай өдөр).

³¹ 明太宗实录 (Мин Тайзун шилү), 永乐四年三月辛丑, 五年五月丙寅、十月壬辰

дараа элч томилон бичиг илгээж, эв найртай байх, энх тайвныг хамтаар эдлэхийг хүсч байв. Харин та элчийг буцаж хариулахгүй байв. Эдүгээ Бай Ху, Зо Хув нарыг томилон учир шалтгааныг олж, жаргал зовлон алин болохыг дээд тэнгэрт мэдэгдэж байна. Үүнийг хаан та сайтар тунгаан бодно уу гэжээ. Мин улс урд хожид нийт тав удаа илгээсэнд, Гүйлич ойшоосонгүй, элчийг ны буцаасангүй гэх ч Мин ши лү-д: 遣鞬鞬僧耳亦赤、也儿吉你儿灰等还。令贵彩币赐勒靶太师右丞相马儿哈咱及头目脱火赤等。 - Татарын лам 耳亦赤, 也儿吉你儿 нарыг буцааж, Ойрадын тайш, баруун гарын чинсан Марханза ба толгойлогч Тохочи нарт эд мөнгө өгүүлэв хилээс гартал хамгаалав. Бас Хө Фү (何福) ба Сун Шөн (宋晟) -д нууцаар зарлиг буулган 耳亦赤乃鬼力赤之师, 或言此必鬼力赤所遣。盖鬼力赤欲西向与瓦剌战, 将徙其家属近南, 而畏备边官军袭之, 故遣来, 以缓官军之出。 - 耳亦赤бол Гүйличийн хүн [элчийг][буцаан] илгээв. Гүйлич баруун тийш Ойрадыг дайлах санаатай, гэрийн хүмүүсээ өмнө зүгт нүүлгэ гэхэд хилийн цэрэг, ноёд дайлахаас айж ... дайлахаар мордохыг алгуурлаж буй гэх буюу 鬼力赤亦欲归附而未决, 故先遣来窥规朝廷之意。 - Гүйличи бууж өгөхийг бодож байна гэтэл шийдэж чадахгүй байна. Иймээс хүн томилон төр засгийн санааг тэнсэж байгаа нь энэ гэж таамаглажээ.

Энэ сурвалжийн мэдээнд Гүйличийн хүн хэмээснийг үзэхэд, Гүйлич Мин улсад элч илгээж байсан тодорхой байна. Үүний зэрэгцээ Мин улсаас Буняшир хаанд элч захидал илгээн харилцаж байсан. Мин Юнлө хуанди [1408 оны нэг сард] тайган Ван Ань (王安) нарыг Буняширт томилон: 如能幡然来归, 加以封爵, 厚以赐资, 律于近塞择善地而居。³² - хэрвээ урьдын бодлоо өөрчлөн дагаж ирвэл цол хүртээн, эд хөрөнгө шагнан сайн газрыг шилж, сууж болно гэсэн утгатай захидал илгээв. Буняшир мөн хариу илгээсэнгүй. 1408 оны таван сард Аругтай зэрэг хүмүүс Гүйличийг хөөж, арван сард Буняширийг Өлзийт цолтой хаан өргөмжилсөн. Дараа жил нь тэрээр Урианханы гурван харуулын монголчуудыг нөлөөндөө оруулж, Хэрлэн голын доод урсгалд орд байгуулж, их сайд Аругтайн дэмжлэгтэй улс орноо захиран суужээ. Юнлө-гийн долоодугаар оны [1409] зуны сүүл сарын цагаагчин гахай өдөр Мин улсаас Гуо Жи (郭驥)-г Монголын [Буняшир] хаанд элчээр илгээж:

(Юнлө-гийн дөрөвдүгээр оны гурван сарын цагаагчин үхэр өдөр, тавдугаар оны таван сарын улаан бар өдөр, арван сарын хар луу өдөр)

³² 明太祖实录 (Мин Тайзун шилү), 永乐六年正月甲子、三月辛酉 (Юнлө-гийн зургадугаар оны нэг сарын хөх хулгана өдөр, гурван сарын цагаагчин тахиа өдөр).

边将得尔部下完者帖木儿等二十二人来,俱言众已推立尔为可汗,尔欲遣使南来通好,联心甚喜。- хилийг сахиж байгаа жанжид [хаан] таны хараат Өлзийтөмөр зэрэг 22 хүнийг олзлов. Тэдний хэлэхээр чамайг нэгэнт хаан ор суулгажээ гэнэ. Чи өмнөш элч илгээж эвсэхийг хүсэж байвал, мөхөс миний сэтгэл маш их баясна ... хэмээгээд 可汗诚能上顺天意,下察人事,使命往来,相与和好,肤主中国,汗主朔漠,彼此永远相安于无事,岂不美哉³³ - хаан та дээш тэнгэрийн санааг үнэнчээр дагаж, доош хүний ертөнцийн явдлыг магадалж, элч илгээн найрамдалтай харилцаж, мөхөс би Дундадыг мэдэж, хаан та говийг [Монгол нутгаа] мэдэж харилцан өнө үүрд халдахгүй байвал сайн биш үү? гэжээ.

Дээрх баримт Мин улсаас Монголын хааны цэрэг - улс төрийн хүч үлэмж нэмэгдсэнийг хүлээн зөвшөөрч байсныг харуулж байна. Гэвч Буняшир, Мин улсын саналыг хүлээн авсангүй, элчийг алжээ. Иймээс Мин улс Ойрадын гурван ванд элч томилон Буняшир хаанд даган орохооос сэргийлэх болсон. Буняшир [Өлзийтөмөр] хаан, Аругтай нар Ойрадыг хэд хэдэн удаа дайлсан хүч тэнцүү, амжилт олсонгүй Хэрлэн голд буцсан тухай Мин улс олж мэдээд улсын элчийг алсан шалтгаар цэрэг илгээн сайн тохиолыг далимдуулан Монголын хаан ордыг мөхөөхөөр шийджээ. Мин улсаас Буняшир хаанд: 遣郭驥等送完者帖木儿等还,期与尔通好,尔乃悖慢,要杀信使,……联明年必亲率大军往征尔罪。³⁴ - Гуо Жи нарыг томилж, Өлзийтөмөр нарыг буцаан, эвсэхийг хүссэн ч та нар оморгорхон сагсуурч элчийг барьж алсан ... мөхөс би дараа жил биеэр их цэрэг дайчлан ял асуун, нэхэмжилнэ гэж сүрдүүлжээ.

Буняшир хааны дараа монголын байдал түгшүүртэй, хаад түргэн түргэн солигдож, Дэлбэг (1411-1415) Эсэхү, Ойрадай (1416-1425), Адай (1416-1438), Ажай тайж (1426-1430) урьдын адил нэгэн зэрэг хаан суусан үед хаад захидал бичиг илгээн Мин улстай харилцсан баримт ховор ажээ. Харин Ойрад болон Зүүн монгол, Урианханы харуулын тайш, ноёдтой харилцсан тухай олон баримт сэлт хадгалагдан үлдсэн.

Нэгэн үе Монголын хаан суусан Адай хааны (1416-1438) тухай 1434 оноос Мин ши лү-д нилээд тодорхой тэмдэглэжээ. Учир нь зүүн Монгол, Ойрадын довтолгоонд өртөн Аругтай сайд нь нас барж, харьяат олон нь сарнин бутарч Адай хаан үлдсэн олноо дагуулан Хатан голын Бор тохойд орж, Мин улсын хилээс холгүй Гань Лая (甘涼)

³³ 明太祖实录 (Мин Тайзун шилү), 永乐七年四月丁丑 (Юнлө-гийн долдугаар оны дөрвөн сарын улаагчин бар өдөр).

³⁴ 明太祖实录 (Мин Тайзун шилү), 永乐七年七月癸酉 (Юнлө-гийн долдугаар оны долоон сарын харагчин тахиа өдөр).

орчим сууж, элч илгээн Мин улстай харилцах болсон. Мин улсын түүх сурвалжид Адай хааныг Сяо Ванцзи (王子) гээд: 欲率众掠凉州、甘肃。³⁵ - олноо дагуулан Лянжөү, Ганьсү орныг дагуулах санаатай байна гэж тандаж байв. [1434 оны 12 сард] Адай хаан, Доржбай Мин улсад элч илгээсэн тухай Ганьсү (甘肃) -гийн Цэргийн ерөнхий захирагч (总兵营) -ийн дээш өргөсөн бичигт: 朵儿只伯率众三千驻牧 ... 去凉州十余里,已绝粮饷,欲来朝归附。且言近至凉州, 失其甥卜鲁罕虎里, 乞还之。³⁶ - Доржбай 3000 хүн дагуулан... Лянжөү-аас арав гаруй газрын зайтай сууж цэргийн амуу, хүнс нэгэнт тасарчээ... Ланьжөү ойролцоо зээ алдаж, буцааж өгөхийг хүсэн байна хэмээсэнд Мин улс: 尔但尽归所掠凉州人口,亦还尔甥³⁷ - Чи Ланьжөү-аас булаасан хүмүүсээ буцаавал, зээг чинь буцаана гэж хариу илгээжээ. [1435 онд] Адай хаан, Доржбай нар Тогооч (托忽赤) нэрт элчийг илгээж, мориор бэлэг өргөж, Мин улстай хэлэлцээр хийхийг хүсчээ. Гэвч, Мин улсаас сүр хүч нь доройтсон Адай хаантай харилцах байдал нь Буняшири болон Аругтайд хандаж байснаас өөр болж:

尔等能识天命,相率来归,许尔休养如故。•今能效顺,亦许自新。尔或稔恶不悛,朕虽欲曲全尔生,如王法何,尔尚筹之,无貽后悔³⁸ -Та нар хувь заяагаа таньж, олон түмнээ дагуулан дагаар ирвэл, та нарыг уридын ёсоор амьдран суухыг зөвшөөрөх болно ... Дагаар ирвээс буруугаа залруулах завшаан олгоно. Эс бөгөөс ... буруугаа мэдэж үл залруулбал мөхөс би хэдийгээр та бүгдийг амьд үлдээн, өршөөн соёрхохыг бодож байсан ч хууль ёсонд хэрхэн нийцэх билээ. Та нар сайтар бодолхийлэгтүн

хэмээн тулган, сэрэмжлүүлсэн байна. Адай хаан, Доржбай хоёул Гань Лян ойролцоо боомтын гадна, зам харилцааг таслан, Ойрадын алба барихаар Мин улсад очсон элч буцаж чадахгүй Мин улсад удаан хугацаанд үлдэж, Мин улсын хил хязгаар түгшүүртэй болжээ. 1437 оны хоёр сард, Мин улс Ойрадын Тогоонд бичиг илгээн, Татарын хулгай Бодидарма болон Адай, Доржбай нар булаан дээрэмдэж, миний хилийг

³⁵ 明宣宗实录 (Мин Шюаньзун шилү), 宣德九年七月丙申 (Шюаньдө-гийн есдүгээр оны долоон сарын улаан бичин өдөр).

³⁶ 明宣宗实录 (Мин Шюаньзун шилү), 宣德九年十二月己未 (Шюаньдө-гийн есдүгээр оныарван хоёр сарын шаргачин хонь өдөр).

³⁷ 明宣宗实录 (Мин Шюаньзун шилү), 宣德九年十二月辛酉 (Шюаньдө-гийн есдүгээр оны долоон сарын цагаагчин тахиа өдөр).

³⁸ 明宣宗实录 (Мин Шюаньзун шилү) 宣德十年正月甲午、十月壬寅 (Шюаньдө-гийн аравдугаар оны нэг сарын хөх морин өдөр, арван сарын хар бар өдөр).

түйвээж, зам харилцаа нэвтрэхгүй болжээ. Мөхөс миний сайд нар цэрэг авч мордон тэднийг устгахыг хүсэж байна. Цэргээ дагуулан баруунаас хойш чиглэн яв, миний цэрэг хилийг дагаж явъя гэж тохиролцон Мин улс, Ойрад Адай хааныг бүслэн дайлах тухай тохиролцжээ. Мөн Адай хаанд бичиг дахин илч элгээн илгээн ... буруугаа хүлээн дагаар ир. 我师一出,尔其毋悔- бид их цэргээр дайлбал чи лавтай харамсах болно гэж сүрдүүлжээ³⁹. Түшиг тулгуур үгүй Адай хаан арга буюу 1437 онд Мин улсад дахин нэг удаа элч илгээжээ. Мин улс хариуд нь Адай хаан, Доржбай нар амь зуух арга хайж, арга буюу хил хязгаарыг довтлон булаан дээрэмдсэн гэж уучилж болно, аймаг олноо дагуулан Мин улсын хилийн ойролцоо оршин суухыг зөвшөөрч, өөрийн хараат болж алба үүрэг хүлээ, үүний тулд угсаа гарал өндөр, зэрэг цол өндөр ноёдыг томилж Мин улсад илгээ, зэрэг хэргэм, шан харамж олгоно, гэрээ хэлэлцээр хий гэж тулгаж, цаг хожихыг оролдож байжээ. Мин улс, Ойрадын тогоонтой хамтран дайлах тухай нэгэнт тохирсон байсан хоёр тал хүч хавсран Адай хааныг цэрэглэн дайлжээ. [1438 онд] Мин улсын элч Ойрадаас Мин улсад буцахдаа:达贼阿台、朵儿只伯等已被脱脱不花王杀死。西北之境,可以无虞 - Татарын дээрэм Адай, Доржбай нар Тогтообух хаанд алагдав. Баруун хойдын хязгаарт зовох зүйлгүй болжээ гэх мэдээг дамжуулсан байна.

Мин Рэньзун [Хунши] (1424-1425) болон Шюаньзун [Шюаньдэ](1425 -1435) хаад улс орны бодлогодоо анхаарал тавьж, монголчуудын дотоод хэрэгт тэр бүр оролцохгүй, дайлахаа зогсоон, илбэн дагуулах, хилийн хамгаалалтаа чангатгах болов⁴⁰.

Мин улсын Жэнтун (正统1435-1449) болоод Жинтайн (景泰1457-1564)-н үед Монголын Тодобух [Тайсун] хаан, Тогоон тайш, Эсэн тайш тус тусдаа Мин улстай харилцаж байсан. Мин улс Тодобух [Тайсун] хааныг хүндлэн хүндээр шагнаж тэдний хоорондох зөрчлийг хурцатгаж байв. Тухайн үеийн Монгол-Мингийн харилцаа, Монгол-Мингийн дайн, Түмүгийн тулалдааны тухай Мин улсын түүхэн сурвалж болон судалгааны бүтээлүүдэд тодорхой өгүүлсэн байдаг тул энд дэлгэрэнгүй өгүүлсэнгүй.

XV зууны дунд үед Харчин Болай Тодобух [Тайсун] хааны хүү Махагүргисийг хаан (1455-1465) өргөмжилжээ. Тэд байгалийн гамшиг,

³⁹ 明英宗实录 (Мин Инзун шилү), 正统二年二月丙子 (Жэнтун-гийн хоёрдугаар оны хоёр сарын улаан хулгана өдөр).

⁴⁰ 论明代洪熙宣德时期的蒙古政策 - Мин улсын Хунши, Шюаньдэ үеийн Монголын талаарх төрийн бодлого, 中州学刊., 1997, Хоёрдугаар хугацаа.

дотоодын зөрчил тэмцлээс зайлан Мин улсын хилд ойртон, алба барих нэрээр элч илгээн арилжаа нэвтрэлцэхийн хамт өвөлдөө өмнө тийш Хатан голын Бор тохой оронд очиж, хавар болохоор хойш буцдаг болжээ. 1455 онд [Дайзун [Жинтай]-гийн зургаадугаар оны зургаан сар] Мархагүргис хаан Болай, Муулихай нар Мин улсад элч илгээж⁴¹ арилжаа хийхийг шаардсан тухай:

Мин улсын түүхэнд: 迺北王子麻儿可儿遣正副使皮儿马黑麻、锁鲁檀、平章昂克、卯那孩、孛罗遣使臣可可宛者赤、板达阿里等进贡马驼至京,言孛罗以阿剌知院杀死也先,率兵攻之,杀败阿剌,夺得玉宝并也先母妻⁴² - Умардын сяо ванцзы Маргүргис, Пирмухамад (皮儿马黑麻) Суругтанг (锁鲁檀), Пинжан Энх (平章昂克) Муулихай (卯那孩) Болой (孛罗) -гийн элч Хөхөм-зэйч (可可宛者赤) Бандали (板达阿里) нарыг элчээр Бээжинд илгээж, морь тэмээ өргөв гэх мэдээнээс үзвэл энэ удаа их хааны элч болон эрхэт түшмэдийн элч хамт иржээ. 1463 оны зургаан сард, Болой болоод Мархагүргис, Манлай (满刺), Болунай (孛罗乃) Уянтөмөр (兀研帖木儿) нарыг Мин улсад элчээр илгээн алба барьжээ.⁴³

[1464 оны Хаврын эхэн сард] Махагүргис хаан, Болой тайш Мандуул (满都), Дөрөөт (朵罗秃) нарыг Мин улсад элчээр илгээн алба барив. 凡千人,贡马三千有奇 - 1000 хүн байж, Албанд өрөгсөн адуу нь 3000 байна гэсэн тэмдэглэл байна. Мандуул (满都) зэрэг 79 хүнд цол зэрэг олгожээ.⁴⁴ Мин улсын магад хуульд ... *өчигдөр орчуулж гаргасан умардын Махагүргис хааны бичигт, тэд элч явуулж, алба барихыг хүсэж байна*⁴⁵ хэмээн дурьдсан нь Монголын хааны элчийн авч ирсэн монгол бичгийг Харь улсын бичиг орчуулах тэнхим (四夷馆) орчуулсны дараа дээш айлтгаж, элчийг боомтоор нэвтрүүлэх тэмдэг бичиг олгодог байсны гэрч юм.

[1465 оны эхээр Махагүргисхаан ба Болой тайш Мин улсад элч илгээж, Бологчи (孛罗赤) зэрэг 2194 хүн Датунд (大同) очсон. Мин улсаас тайган Е Да (叶达) нарыг Датунд томилж тэднийг угтжээ. 存留十之

⁴¹ Мин улсын судар. Олон шастир. 327 дугаар дэвтэр. Татар. УБ. 2018, 147.

⁴² 明英宗实录 (Мин Инзун шилү), 景泰五年十月甲午, 六年四月戊戌 (Жинтай-гийн тавдугаар оны арван сарын хөх морин өдөр, зургадугаар оны дөрвөн сарын шар нохой өдөр)

⁴³ 明英宗实录 (Мин Инзун шилү), 天顺七年六月丁亥 (Тяньшүн-ий долдугаар оны зургаан сарны улаагчин гахай өдөр)

⁴⁴ 明英宗实录 (Мин Тяньшүн шилү), 天顺八年春正月丁丑 (Тяньшүн-ий наймдугаар оны хаврын эхэн сарын улаагчин үхэр өдөр)

⁴⁵ 明英宗实录 (Мин Тяньшүн шилү), 天顺八年正月乙丑 (Тяньшүн-ий наймдугаар оны нэг сарын хөхөгчин үхэр өдөр).

七,给与口粮下程,在边牧放,仍命守臣严防护之⁴⁶-10-ны 7 хувийг [хилийн боомтод] үлдээж, ам, хүнс эд хогшил өгч, хил дагуу малжиж, хил сахигч ноёныг томилон хамгаалуулав”.

Махагүргис хааны ах Моолон хаан сууринд өргөмжлөгдсөн ч цөөн жил хаан суусан. Тухайн үеийн улс төрийн амьдрал ээдрээтэй, Мин улстай харилцсан нь тэмдэглэл цөөн үлджээ. Рашпунцагийн түүхэнд ... Моолон хаан, Ван Муулихай хоёр засаг төрийг төвшитгөн Монгол хийгээд Ойрад бүхнийг эрхэндээ оруулан, улс иргэн амаржлаа. Тэр үед Мин улсын Чөнхуа (1465-1487) II [1466] онд элч зарж алт мөнгө, торго магнаг тэргүүтнийг хүргэсэнд, хааны түшмэд [Мин улсын] хаан бидний гарт [бөхийн буй нь] улс төр эрх биш самуунтай амуй ... даруй цэрэг морио засаж Мин улсыг доройтуулая гэж санал гаргажээ. Хаан ... Бидний улс самуурснаас ихэд зовон зүдлээ. Эдүгээ баахан тогтнож атал ... гагц тэдний бэлгийг авч хоёр улс элсвээс зохилтой, эе зохицсугай хэмээн ам авч ... элч гарган [Мин] улсад хүргүүлбэй⁴⁷ гэж өгүүлсэн байдаг. Энэ нь дагаар орсон монгол ноён [Мань Жюнь] Кайчөнд бослого гарган, Мин улсын дотоодод түгшүүртэй тул монголчуудтай найрамдах бодлого баримталж байсантай холбоотой.

Мөн Мандуул хаан, түүний харьяат ноёд тус тус Мин улсад элч илгээн 1750 гаруй хүн Мин улсад очжээ. Мин улс ... 使臣许五百人来京, 马择其良者送京, 余给边军骑操。⁴⁸ - элчээс 500 хүн Бээжинд ирж, адууны сайнаас нь шилж Бээжинд хүргэ. Үлдснийг нь хилд цэрэгт өг гэх мэт мэдээ тэмдэглэгдэн үлджээ.

Батмөнх Даян хаан (1479-1517) засаг захиргааны шинэчлэлт хийж, хааны хот [нийслэл] өмнө тийш шилжин Цахарт төвлөрч Монгол – Мин хоёр улс элч солилцон алба барих, арилжаа худалдаа улс төр, эдийн засгийн харилцаа тогтворжсон. 1488 оны таван сард Даян хаан анх удаа элч илгээсэн тухай Мин улсын түүхэнд:

[Хунжы (1488–1505)-гийн тэргүүн оны зун]... Исмайл үхэж, халдан ирэгсэд дахин Шяованзы (小王子) хэмээн[э] бас Баянмөнх ван [Батмөнх хаан-Д.Э] гэгч бөлгөө гээд ...先是北虏小王子率部落潜住大同近边, 营

⁴⁶ 明宪宗实录 (Мин Шяньзун шилү), 成化元年春正月庚申 (Чөнхуа-гийн тэргүүн оны хаврын эхэн асрын цагаан бичин өдөр).

⁴⁷ Рашпунцаг. Болор эрх. Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал. XIV. УБ. 2006, 541-542.

⁴⁸ 明宪宗实录 (Мин Шяньзун шилү), 成化十一年六月戊戌 (Чэнхуа-гийн арван нэгдүгээр оны зургаан сарын шар нохой өдөр).

亘三十余里，势将入寇。至是奉书求贡，书辞悖慢，自称大元大可汗。⁴⁹
 - Умардын Шяованзы (小王子) [Батмөнх Даян хаан] харьяат ноёдоо дагуулан Датун-ы ойролцоо [хилээс] 30 гаруй газрын зайтай байна. Булаан, дээрэмдэх шинжтэй ... бичиг илгээж, алба барихыг хүсэв. Үг үсэг нь омгорхог, биеэ Их Юань улсын хаан гэж байна⁵⁰... дээрмүүд [монголчууд] хил дээр ирж хариу хүлээж байна гэжээ. Мин улсын хаан ... хэрэв Монголын Бага ван [Батмөнх хаан] үнэхээр алба барих хүсэлтэй бол элчийг хил нэвтрүүлж, ёс журмын дагуу угтахыг гадаад дотоод хэрэг эрхэлсэн түшмэдүүдэд сонордуул, хэрэв алба өргөхөөр ирэхгүй бол хилийн бэхлэлтийг чангатгаж, дайтахад бэлэн бай⁵¹ гэж байв.

Даян хаан, Мин улстай албан арилжаа хийхийг зөвшөөрүүлж, зургаан сард элч 1530, адуу 4930-ийг Мин улсад илгээжээ. Мин улс 500 хүнийг Бээжинд очихыг зөвшөөрч бусдыг нь хил орчим үлдээв⁵², хэдэн сарын дараа Даян хаан бас дахин элч илгээжээ⁵³, 1490 оны хоёр сард Мин улсаас 北及瓦剌进贡使臣人等, 逸北许一千一百名入关, 四百名入朝. 瓦剌许四百名入关, 一百五十名入朝⁵⁴- [Даян хааны] 1100 хүн боомтоор нэвтэрч 400 хүн нь, Ойрадын 400 хүн боомтоор орж, 150 хүн хаанд бараалхана гэж Даян хаан болон Ойрадын элчийн хамт хүлээн авахаар тогтоосон байна. 1491оны хоёр сард 逸北伯颜猛可王并瓦剌太师火儿忽刀遣使臣努力等来朝贡 - умардын Баямөнх [Батмөнх] хаан, Ойрадын тайш Хурах (火儿忽) нар, Нү Ли (努力) нарыг элчээр илгээв ...⁵⁵, [1496 оны таван сард] Монгол 3000 хүнийг элчээр илгээж, Мин улсаас 1000 хүнийг нь Бээжинд очихыг зөвшөөрчээ. Хожим нь Даян хаан Мин улсын шан харамж дэндүү бага гэж Мин улсын хилд халдах болсон⁵⁶, Даян хаан бараг хоёр жил элч илгээсэнгүй, 1498 оны

⁴⁹ 明孝宗实录 (Мин Шяозун шилү), 弘治元年五月乙酉 (Хунжы-гийн тэргүүн оны таван сарын хөхөгчин тахиа өдөр).

⁵⁰ 明孝宗实录 (Мин Шяозун шилү), 弘治元年五月乙酉 (Хунжы-гийн тэргүүн оны [1488] таван сарын хөхөгчин тахиа өдөр).

⁵¹ 明孝宗实录 (Мин Шяозун шилү), 弘治元年五月乙酉 (Хунжы-гийн тэргүүн оны зургаан сарын улаагчин тахиа өдөр).

⁵² 明孝宗实录 (Мин Шяозун шилү), 弘治元年六月癸卯 (Хунжы-гийн Анхдугаар оны зургаан сарын харагчин туулай өдөр).

⁵³ 明孝宗实录 (Мин Шяозун шилү), 弘治元年八月己未 (Хунжы-гийн Анхдугаар оны найман сарын шаргачин хонин өдөр).

⁵⁴ 明孝宗实录 (Мин Шяозун шилү), 弘治三年二月癸巳 (Хунжы-гийн Гуравдугаар оны хоёр сарын харагчин могой өдөр).

⁵⁵ 明孝宗实录 (Мин Шяозун шилү), 弘治四年二月乙丑、辛巳 (Хунжы-гийн дөрөвдүгээр оны хоёр сарын хөхөгчин үхэр өдөр, цагаагчин могой өдөр).

⁵⁶ 明孝宗实录 (Мин Шяозун шилү), 弘治九年五月己未 (Хунжы-гийн есдүгээр оны

хоёр сард 6000 хүнийг элчээр илгээж, 2000 хүн хилээр орж, 500 хүн Бээжинд очихыг зөвшөөрчээ⁵⁷. Үүний дараа Монгол ба Мин улсын элчин харилцаа хэдэн жил тасарч, монголын олон аймгууд Мин улсын хил дагуу орыг булаан дээрэмджээ гэх мэт олон мэдээ тэмдэглэгдэн үлдсэн байна.

1504 оны гурван сард Даян хаан 6000 хүнийг Мин улсад элч томилон бичиг захидал илгээжээ. Гэтэл Мин улс, *Монголын элчийг авч ирсэн бичгийн он сар нь таарахгүй буцаж он сарыг соль* хэмээсэнд Монголын элч зөвшөөрсөнгүй:

往年谋入，贡书已成，以事不果。番地纸难得，故仍旧书，无他意⁵⁸-
өнгөрсөн жил алба барихаар тогтож, өргөх бичиг нэгэнт хийгээд байна. Гэтэл учир явдал бүтсэнгүй. Хойд газар цаас олдоход хүчир учраас хуучин бичгийг хэрэглэв. Өөр санаагүй ... гэж тайлбарласанд Мин улс 2000 хүн алба барихыг зөвшөөрчээ.

Даян хааны элчийн тоо нь олон, илгээсэн бичигтээ үг үсэг нь омгорхог, биеэ их Юань улсын хаан гэж, Мин улстай илт дээрэнгүй харилцах болсон нь энэ үед Монголын хүчин ихэд нэмэгдсэн болохыг харж болно. Мин улсаас Монголын элчийн тоог тогтоосон харьцаанаас үзэхэд, Мин улс нь Монголын хааныг хүлээн зөвшөөрч уламжлал ёсоор харилцаж байсан. Гэвч ямар шалтгаан байсан нь тодорхойгүй, Даян хаан дахин алба барихаар элч илгээсэнгүй, харин Датун хавийг булаан дээрэмдэх болжээ⁵⁹. Бодь - Алаг, Дарайсун, Түмэн, Лигдэн хаадын үед хоёр улсын хаадын уламжлалт харилцаа тасралтгүй үргэлжилжээ.

Ийнхүү 1369 оноос Мин улсын хаан Жу Юаньжан, Юаны эзэн Тогоонтөмөр хаанд анх удаа элч илгээн хоёр улсын албан ёсны элчин харилцаа эхэлж Лигдэн хааны үе хүртэл Монгол хаад тус тус элч захидал илгээн харилцсан тухай, Мин улсын түүхийн сурвалж бичигт тэмдэглэгдсэн баримтыг тоймлон өгүүллээ.

таван сарын шаргачин хонин өдөр).

⁵⁷ 明孝宗实录 (Мин Шяозун шилү), 弘治十一年二月月己巳 (Хунжы-гийн арван нэгдүгээр оны хоёр сарын шаргачин могой өдөр).

⁵⁸ 明孝宗实录 (Мин Шяозун шилү), 弘治十七年三月壬午 (Хунжы-гийн арван долдугаар оны гурван сарны хар морь өдөр).

⁵⁹ 明孝宗实录 (Мин Шяозун шилү), 弘治十七年三月壬午, 六月癸未 (Хунжы-гийн арван долдугаар оны гурван сарны хар морь өдөр, зургаан сарын харагчин хонь өдөр).

Монгол хаадын эдгээр захидал бичгийн эх, хуулбар, орчуулга одоохондоо олдоогүй байгаа ч түүхэн цаг үеийн байдал, хоёр улсын харилцааны зорилго, захидал бичгийн агуулгыг сурвалжийн мэдээнээс тодорхой харж болно. Мин улсаас Монгол хаад, ноёдод ноёдод илгээж байсан захидал ямар байсныг адилтгаж болох нэг захидал – 1453[2] онд Мин улсын Жинтай хуандигаас Түрэгийн Янлирги хэмээх ноёд илгээсэн хятад, монгол хавсаргасан захидал Туркийн Топкани Ордон музейд хадгалагджээ⁶⁰. Тэр захидал нь хэдийгээр Монголын эзэнт гүрний түүх үеэ өнгөрөөсөн ч монгол хэл, монгол бичиг улс түмнүүдийн харилцааны хэрэглүүр хэвээр байсныг харуулж байна. Захидлын хэв маяг, агуулга нь дээр дурьдсан монгол хаад, ноёдод Мин улсаас илгээж байсан захидлын хэв маяг, агуулга адилавартай байсан бололтой. Үүнд:

Хааны зарлиг Лар газарын [тэргүүн] ... чи үе үе дор баруун этгээдэд сууж Тэнгэрийн агуурыг хүндлэн даган, дээдсийг эрх[эм]лэн хүн зарж холоос ... үзүүлэн ирснээс чин үнэн зориг үзүүлбэй. Зорин чамд [зориулан] өнгөтөн дотоод төргэс [өнгө бүрийн торго] соёрхож илгээв. Чиний сайн зоригийн тул харилцмой.

Чи түлэдэндэ [улам] дээр төргэс [өнгө бүрийн торго] Тэнгэрийн зоригийг даган үүрд түшмэлийн дүр бээ бэхлэн аваас мөн миний энэрэн асрахуй зориг дор адил молмуй хэмээн бичиг өгөв. Соёрхож илгээх төргэс [өнгө бүрийн торго]: Бүр цэцэгтэй үүлэн арт ногоон [өнгийн торго] нэг, ... нарийн [жигжиг] цэцэгтэй лама нэг, Бүр нарийн [жигжиг] цэцэгтэй ногоон [өнгийн торго] нэг, ... нарийн [жигжиг] цэцэгтэй ... [улаан] [өнгийн торго] нэг ... Өнгөт хив [торго]: Улаан дөрөв. Лама дөрөв. Хэнэтэй [Жинтай] гуравдугаар он арван нэгэн сарын хорин есөн⁶¹ гэжээ.

Монгол хаад, ноёд өөрийн санаа зоригийг илтгэсэн захидлыг монгол хэлээр бичиг үйлдэж, элчээр дамжуулан илгээж байсан. Мин улс, үлдэж хоцорсон болон дагаар орсон монгол хүмүүсийг [олон элчийн нэр тэмдэглэгдэн үлджээ] элчин харилцаанд ашиглаж Монголд илгээж байсан тул үг хэл, үсэг бичгийн үл ойлголцол эхэн үедээ бага байжээ. Улмаар Мин улсад очих элчийн тоо нэмэгдэн, албан бичиг захидал орчуулах явдал зайлшгүй чухал болж Юнлө (永樂) (1403-1424)-гийн

⁶⁰ Уйгаржин монгол үсгийн дурсгалууд. Эмхэтгэсэн Дов. Үндэсний хэвлэлийн хороо. 1980, 467-476.

⁶¹ Уйгаржин монгол үсгийн дурсгалууд. Эмхэтгэсэн Дов. Үндэсний хэвлэлийн хороо. 467-476.

үед *Харь улсын бичиг орчуулах байгуулга* буй болжээ. Мин улсын хууль зүйн тэмдэглэлд өгүүлснээр Монгол, Зүрчин, Баруун хязгаар, Хотон, Төвөд, Бирм зэрэг гадаадын элчид зориулсан найман салбар бүхий *Харь улсын бичиг орчуулах тэнхимийг* үсэг бичиг орчуулагч, хэлмэрч хэмээх хэлтэстэй байгуулах тухай заажээ. Ирсэн харийн элчид хэлмэрч, орчуулагч тохируулж, үг хэл, үсэг бичгийг орчуулан нэвтрэлцэх үүрэгтэй байгууллага байжээ. 1549 оноос олон жил хэлмэрч хийсэн, харийн хүн [элч] байсан үгүй нь хамаагүй, харийн хэлийг сайн мэддэг, туршлагатай хүнийг сонгож багш болгоно. Хэлмэрч багш өдөр бүр харийн хэлийг уншиж дагалдуулан суралцуулах болсон.

Монгол-Мин хоёр улсын захидал бичиг нь хоёр улсын хаадын дипломат захидал, алба арилжаа хийх тухай, цагийн үеийн байдал зэргийг харилцан мэдээлсэн, тусламж дэмжлэг хүссэн, Мин улсаас ухуулах захидал, сүрдүүлсэн, шан хишиг, цол хэргэм олгосон тухай, хувийн шинжтэй гэх мэт олон төрөл болно. Хоёр талын харилцааны захидал бичгүүд хятад хэлээр, монгол хэлээр монгол үсгээр, монгол хэлээр хятад галигаар тэмдэглэсэн захидал, хятад монгол хэлээр хавсарган үйлдсэн дурсгалууд түүхийн үнэ цэнэтэй анхдагч сурвалж болох нь маргаангүй. Мин-Монгол хоёр улсын жанжид, ноёд харилцсан захидал бичгүүдийн эзлэх хувь олон, бидний үед уламжлан ирсэн нь цөөнгүй байдаг. Харин Монгол хаадын Мин улстай харилцсан захидал бичиг, ялангуяа Монгол хаадын монгол хэлээр монгол бичгээр үйлдсэн тамга бүхий захидал бичгийн эх хувь бидний үед хараахан илрээгүй байгаа ч өмнө дурьдсан батлах олон баримт ийнхүү хадгалагдан үлджээ. Монгол хаадын захидлын эх, хуулбар, орчуулгын эх олдоно гэж найдаж байна.